

БНХАУ-ЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО, СТРАТЕГИЙН СУДАЛГАА

Б.Отгонсүрэн
ССХ-ийн ОУБНСС-ын эрхлэгч доктор (PhD)

Түлхүүр үг: БНХАУ, үндэсний аюулгүй байдал, язгуур ашиг сонирхол, аюулгүй байдлын хууль, бодлого, стратеги

БНХАУ-ын үндэсний аюулгүй байдлын бодлого, стратегийг судлахын урьд Хятад улс язгуур ашиг сонирхлыг (核心利益 хят., core interest анг.) хэрхэн тодорхойлж ирснийг тодруулах нь зүйтэй юм.

Өрнөдийн судлаачид 2000 оноос эхлэн Хятадын хэвлэл мэдээллийн хэрэгслээр үндэсний аюулгүй байдал, язгуур ашиг сонирхол гэсэн үг хэллэг олонтаа дурдагдах болсныг тэмдэглэдэг. Тэдний үзэж буйгаар “язгуур ашиг сонирхол” -ыг анх 1980-1990 оны үеэс хамгийн их анхаарал хандуулж буй асуудал (重大关切хят.), үндсэн ашиг сонирхол (根本利益 хят.) гэх зэргээр илэрхийлж иржээ. Карнейгийн институтын шинжээч Майкл Свэйний¹ хийсэн судалгаагаар 2004 оноос эхлэн Хятадын албаны болон судлаачдын түвшинд хэвлэл мэдээллийн хэрэгслээр Тайваний асуудлыг язгуур ашиг сонирхол буюу улсын бүрэн эрхийн асуудалтай холбон тайлбарлах болсон. Улмаар 2006 оноос хүрээгээ тэлж Төвөд, Шиньжаантай холбоотой асуудлыг ч язгуур ашиг сонирхлын нэг хэсэг хэмээх болжээ.




График 1. Хятадын Ардын өдрийн сонин (人民日报)-д
“язгуур ашиг сонирхол” гарсан давтамж (2005-2016)

1 Michael D.Swaine China's Assertive Behavior Part One: On “Core interestests”




График 2. Синьхуа агентлаг (新华社)-ийн мэдээнд “язгуур ашиг сонирхол” гарсан давтамж (2005-2016 он)

Хятадын удирдагчдын түвшинд анх 2009 оны 7 дугаар сард болсон Хятад-Америкийн стратегийн яриа хэлэлцээний үеэр язгуур эрх ашиг гэж юу болохыг явцуу утгаар хөндсөн ажээ. БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн гишүүн асан Дай Бингуогийн тодорхойлсноор

1. Хятадын улс төрийн тогтолцоо
2. Улсын бүрэн эрх, газар нутгийн бүрэн бүтэн байдал
3. Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжил

Үүнээс улбаалан албан ёсны баримт бичигт буюу 2011 оны БНХАУ-ын Энх тайванч хөгжлийн цагаан ном (和平发展白皮书2011 хят.)-ын Энх тайванч хөгжлийн зорилго хэмээх II бүлгийн Гадаад таатай орчин бүрдүүлэх тухай дэд хэсэгт “Хятадын батлан хамгаалах салбарын модернизацийн зорилго бол улсын бүрэн эрх, аюулгүй байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалж хөгжлийн ашиг сонирхлыг хангах юм” хэмээн албан ёсоор оруулжээ. Дашрамд дурдахад энэхүү цагаан номонд “ашиг сонирхол” гэдэг үг 25 удаа түүнээс “язгуур ашиг сонирхол” 5 удаа давтагдсан байна.

2014 онд БНХАУ-ын ҮАБЗ байгуулагдаж анхдугаар хурлаараа 11 чиглэл бүхий “Цогц аюулгүй байдлын үзэл” (цаашид цогц үзэл гэх, 总体安全观 хят.) баталсан байдаг. Гэхдээ ҮАБЗ байгуулагдахаас өмнө энэ чиглэлд ажилладаг ХКН-ын нэгжүүд байсан. ҮАБЗ байгуулагдсанаар үндэсний аюулгүй байдалд хамаарах гадаад, дотоод асуудлыг хамтад нь тохируулан хариуцах үүрэгтэй болсон юм.

Энэ “цогц үзэл”-ийн зорилго нь хүний аюулгүй байдал буюу ард иргэдийн амьдарлын баталгааг хангах, улс төрийн системийг бэхжүүлэн хадгалах, хөгжлийн ашиг сонирхлоо хамгаалах гэсэн гурван зарчимд суурилан Хятадын онцлогтой аюулгүй байдлыг хангахад чиглэнэ хэмээн тодорхойлсон. “Цогц үзэл” нь 11 чиглэлтэй. Үүнд,

1. Улс төрийн аюулгүй байдал
2. Газар нутгийн аюулгүй байдал

3. Цэрэг, батлан хамгаалахын аюулгүй байдал
4. Эдийн засгийн аюулгүй байдал
5. Соёлын аюулгүй байдал
6. Нийгмийн аюулгүй байдал
7. Шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал
8. Мэдээллийн аюулгүй байдал
9. Экологийн аюулгүй байдал
10. Нөөц баялгийн аюулгүй байдал
11. Цөмийн аюулгүй байдал гэсэн 11 салбарыг тодорхойлжээ.

2019 онд Хубэй мужийн Ухань хотоос дэгдсэн шинэ төрлийн титэмт вирусны халдвар дэлхий дахинд тархсаны улмаас 2020 оны 10 дугаар сард БХАТИХ-ын XIII чуулганы 22 дугаар бага хурлаар био аюулгүй байдлын тухай хууль баталснаар цогц аюулгүй байдлын үзэл баримтлал 12 чиглэлтэй болсон. 2021 оны 4 дүгээр сарын 15-наас хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэх энэ хуулинд шинээр тархаж буй халдварт өвчин, гэнэтийн тахал дэгдэлтийн үеийн биотехнологийн судалгаа, боловсруулалт түүний хэрэглээ болон тодорхой эрсдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах талаар заалтууд оруулсан.

Дээр дурдсан “Цогц үзэл”-ийг баталснаас 1 жилийн дараа буюу 2015 онд БХАТИХ-ын XII чуулганы 15 дугаар бага хурлаар баталсан Үндэсний аюулгүй байдлын тухай хуулинд “Үндэсний аюулгүй байдал гэж төрийн эрх, улсын бүрэн эрх, нэгдмэл байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал, ард иргэдийн амьдралын баталгаа, эдийн засаг нийгмийн тогтвортой тасралтгүй хөгжил болон бусад язгуур ашиг сонирхол (根本利益 хят.)-д гаднаас ирэх аливаа хэлбэрийн аюул заналгүй, тогтвортой, аюулгүй байхыг хэлнэ хэмээн тодорхойлсон байдаг.

Энэ “Цогц үзэл” болон Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн аль алинд үндэсний аюулгүй байдлыг хангах арга замыг тодорхойлоогүй байна.

Гэвч дээр дурдсан Дай Бингуогийн тодорхойлолт, “Цогц үзэл”, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн үзэл санаа, зорилтын эрэмбийг харвал Хятадын ард түмний амьдралын баталгаа, нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжил ямагт язгуур ашиг сонирхлыг нэн тэргүүний чиглэл байж иржээ. Энэ нь Хятадын удирдагчийн дэвшүүлсэн “Бүс ба зам” санаачилга¹, “Хоёр зуун жилийн зорилт” (两个百年目标 хят.)-д ч тусгалаа олсон нь хөгжлийн бодлого, үндэсний аюулгүй байдлын харилцан нарийн уялдаатай төрийн бодлогын залгамж чанарыг илэрхийлж байдаг. “Хоёр зуун жилийн зорилтын” нэг нь хүн амын дундаж чинээлэг давхаргыг тэлэхэд чиглэсэн. Одоогийн байдлаар ДНБ 10.4 их наяд ам.доллар нэг хүнд ногдох ДНБ 7800 ам.доллар байгааг 2021 он гэхэд тус бүр 17 их наяд ам.доллар, 12000 ам.доллар болгож ахиулах ажээ².

Мөн Хятадын нэн тэргүүний язгуур ашиг сонирхол юу вэ гэсэн асуултад

1 Баруун Хятадыг нээн хөгжүүлэх (西部开发), Зүүн Хятадыг сэргээн хөгжүүлэх (东北振兴发展) зэрэг дотоодын бүсчилсэн хөгжлийн төлөвлөгөөтэй нягт уялддаг.

2 Дэлхийн банкны ангиллаар нэг хүнд ногдох ДНБ 12000 ам.долларт хүрвэл дундаж ангилалд тооцдог.

Глобал таймс (环球时报хят.) сонины ерөнхий редактор Ху Шижинь нэгдүгээрт, эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжил; хоёрдугаарт, улс төрийн тогтвортой хөгжил; гуравдугаарт, модернизацийг амжилттай хэрэгжүүлэх гэжээ. Хэдийгээр үргэлж сөхөгддөг газар нутгийн маргаан язгуур эрх ашгийг хөндөж байдаг боловч дотоодын хөгжилд саад учруулах хэмжээнд хүрээгүй учир эрэмбийн хувьд нэгдүгээр асуудал биш¹ гэж хариулсан нь ор үндэсгүй хариулт биш бөгөөд бидний дүгнэлтэд нийцэж байна.

Үндэсний аюулгүй байдлын тухай хуулинд зааснаар Төрийн Зөвлөлөөс үндэсний аюулгүй байдалтай холбоотой хууль баталж, хэрэгжилтийг хянан холбогдох шийдвэр, тушаалыг боловсруулах үүрэг хүлээсэн. Энэ чиг үүргийнхээ хүрээнд дотоодын үндэсний аюулгүй байдлын эрх зүйн орчныг сайжруулахаар дараах хуулиудыг батлан хүчин төгөлдөр хэрэгжүүлж байна. Үүнд,

1. БНХАУ-ын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль 2015 (中华人民共和国国家安全法)
2. БНХАУ-ын Тагнуулын тухай хууль 2018 (中华人民共和国反间谍法)
3. БНХАУ-ын кибер аюулгүй байдлын тухай хууль 2016 (中华人民共和国网络安全法)
4. БНХАУ-ын терроризмтай тэмцэх тухай хууль 2018 (中华人民共和国反恐怖主义法)
5. БНХАУ-ын цөмийн аюулгүй байдлын тухай хууль 2017 (中华人民共和国核安全法)
6. БНХАУ-ын Хонконгийн засаг захиргааны онцгой бүсийн аюулгүй байдлын тухай хууль 2020 (中华人民共和国香港特别行政区维护国家安全法) тус тус баталжээ.

Эдгээр хуулийн агуулгыг авч үзвэл иргэдийн хүлээх үүрэг, хариуцлагыг маш нарийн тодорхой заасан байдаг. Тухайлбал, ААН хилийн чанадад үйл ажиллагаа явуулахдаа шаардлагатай тохиолдолд төрийн тусгай байгууллагыг санхүүгийн туслалцаа болон мэдээллээр хангах үүрэг хүлээнэ; БНХАУ-д үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын байгууллага, ААН-ийг шаардлагатай мэдээллийг Хятадын талд хүлээлгэн өгөх зэрэг нэлээдгүй хатуу хариуцлага тусгасан нь хүний эрх, эрх чөлөө, олон улсын нийтийн эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн, бизнесийн эрх чөлөөг боомилсон хэмээн шүүмжлэгдэж байгаа билээ. Аливаа эрх мэдэл, түүний төвлөрлийг хууль батлах замаар хийдэг арга туршлага энд хэрэгжиж байна гэж үздэг эрх зүйчид ч цөөнгүй бий.

Үндэсний аюулгүй байдлын чиглэлээр хууль батлан хэрэгжүүлэхийн зэрэгцээ аюулгүй байдлын бодлогын бичиг баримтыг боловсруулан баталсан байдаг. Тухайлбал,

- Энх тайванч хөгжлийн цагаан ном (和平发展白皮书, 2011)
- Үндэсний аюулгүй байдлын судалгааны тайлан цэнхэр ном (中国国家安全研究报告, 2014)

1 胡锡进: 什么是中国第一大核心利益并非领土争议<https://news.sina.com.cn/c/2018-11-26/doc-ihpevhck7086010.shtml>

- Хятадын цэргийн стратеги (中国的军事战略, 2015)
- Ази, Номхон далайн бүс нутаг дахь аюулгүй байдлын хамтын ажиллагааны бодлого (中国的亚太安全合作政策, 2017)
- Шинэ эриний Хятадын батлан хамгаалах цагаан ном (新时代的中国国防, 2019)
- Умард торгоны зам буюу арктикийн стратеги цагаан ном (中国的北极政策白皮书, 2018) зэрэг болно.

БНХАУ-ын эдийн засгийн өсөлт, батлан хамгаалахын хүчин чадал нэмэгдэж улсын нэгдмэл хүч (国家综合实力 хят.) бэхжихийн хэрээр дотоодод нийгмийн шинэ асуудлууд үүсч байв. Үүний зэрэгцээ бүс нутаг, олон улсад идэвхтэй гадаад бодлого явуулах болсноор өөртөө итгэх итгэл бэхжин “Маргаант асуудлыг сөхөлгүй өөрт таатай цагийг хүлээх” (韬光养晦 хят.) Дэн Сяопиний аядуу гадаад бодлогын зарчим 2013 оноос хатуу байр суурь баримтлах (奋发作为¹ хят.) болж өөрчлөгдсөн гэж Хятадын судлаачид дүгнэдэг². Мөн энэ байр сууриа хүлээн зөвшөөрүүлэх албадлагын (coercive анг.) арга хэмжээ авч хэрэгжүүлэх болсон юм.

Албадлагын дипломат үйл ажиллагааг цэргийн бус албадлага буюу хүч хэрэглэхгүйгээр зорилтот улсыг байр суурь, хандлагаа өөрчлөхөд хүргэх шахалт үзүүлэх арга ажиллагаа хэмээн өрнөдийн эрдэмтэд тодорхойлдог. Үүнд,

- Эрс буруутгасан байр суурь илэрхийлэх
- Товлогдсон аливаа түвшний айлчлалыг цуцлах
- Худалдааны хориг тавих буюу импортоо бууруулах
- Тарифын ба тарифын бус саадыг нэмэгдүүлэх
- Чөлөөт худалдааны хэлэлцээрийг тодорхойгүй хугацаагаар хойшлуулах
- Жуулчлалаа зогсоох зэргээр илэрдэг байна.

Энэ арга хэмжээг олон улсын түвшинд албан ёсоор зарладаггүй. Ихэвчлэн язгуур ашиг сонирхлыг хөндсөн гэж үзэж байгаа улсад энэ арга хэмжээг хэрэгжүүлж байдаг.

Ийм арга хэмжээ авч хэрэгжүүлэх болсон нь БНХАУ-ын дарга Ши Жиньпиний Мао Зэдун мэндэлсний 120 жилийн ойгоор хэлсэн “Хэн ч биднийг язгуур эрх ашгаа арилжиж, газар нутаг, улсын бүрэн эрх, аюулгүй байдал, хөгжлийн эрх ашгаа хохироох үр дагаварт хүргэж чадахгүй” гэсэн үгээр нотлогдох юм.

Сүүлийн 10 жилд Хятадын зүгээс Австрали, ЕХ, Зүүн Азийн 27 гаруй улс оронд нийт 152 удаагийн тохиолдолд “албадлагын” (coercive) дипломат ажиллагаа явуулсан хэмээн Австралийн стратегийн бодлогын хүрээлэнгийн судалгаанд³

1 Зүүн Хань улсын сэтгэгч, бурхангүй үзлийн төлөөлөгч Ван Чунгийн “Тэнцвэр” I бүлэг номд гардаг. 东汉 王充 《论衡·初稟篇》

2 2013 онд Ши Жиньпин Хөрш оронд баримтлах гадаад бодлогын ажлын хурлаар анх энэ үгийг хэрэглэсэн.

3 “CCP’s Coercive diplomacy” Australian Strategic Policy Institute, Policy Brief Report No. 36/2020, Sep 1, 2020

дурдсан байна. Бүс нутгаар авч үзвэл, Европт 29 буюу хамгийн их, Австрали, Шинэ Зеландад 20, АНУ-д 19, Зүүн Азид 16 удаа албадлагын арга хэмжээ авсан ажээ. Эдгээр улс, компаниудын 82.7 хувь нь Хятадаас албан ёсоор уучлалт гуйсан гэсэн судалгаа байна¹.

Тухайлбал, Тайваний удирдагчдын явуулж буй эх газрын Хятадаас бие даасан гадаад бодлого, үйл ажиллагааг боомилох зорилгоор явуулсан Хятадын эдийн засгийн шахалтын улмаас Ази, Номхон далайн 18 улс Тайваньтай дипломат харилцаагаа тасалж үр дүнд нь тэр даруй их хэмжээний эдийн засгийн тусламж хөрөнгө оруулалт авч байв. Улмаар 2019 оны 10 дугаар сард Бээжингийн Сяншань форумын үеэр БНХАУ-ын БХЯ-ны сайд Вэй Фөнхө Тайваний салан тусгаарлалтын эсрэг хүч хэрэглэхэд бэлэн буйгаа зарлаж² байв.

Японы хувьд 2010, 2012 онд арлын маргаантай холбоотойгоор Хятад дээд хэмжээний уулзалт, айлчлалаа цуцалж, аялал жуулчлалын хориг тавьж байв. Мөн БНСУ пуужингаас хамгаалах систем (ТНААД) байршуулах болсны улмаас Лотте группийн салбар дэлгүүрүүдийг хааж, Чэжү арал руу зорьсон жуулчлалыг зогсоож байв.

Хятадаас 2010-2020 онд Зүүн Азийн бүс нутгийн 16 оронд авч хэрэгжүүлсэн албадлагын арга хэмжээ авагдсан улсуудын тухай судалгаанд Монгол Улс ордог.

2016 онд XIV Далай лам Монгол Улсад хүрэлцэн ирснийг эсэргүүцсэн Хятадын ГХЯ-ны хэвлэлийн төлөөлөгч Хуа Чунь ин “Төвөд бол Хятадын бүрэн эрх, газар нутгийн бүрэн бүтэн байдал, Хятадын *язгуур ашиг сонирхолтой* холбоотой асуудал. Хятадын тал Төвөдийн асуудлаар ганхашгүй байр суурь баримталдаг. Монголын тал энэ асуудлаар сургамж авч Хятадын *язгуур ашиг сонирхлыг* хүндэтгэн амлалтаа биелүүлж хоёр талын харилцааг хэвийн болгоход хүчин чармайлт гаргана гэдэгт найдаж байна” гэж мэдэгдсэн юм.

Эдийн засаг тооцоолж болох үзүүлэлтээр илэрч байдаг тул хохирлыг хэмжиж болдог. Харин улс төр хэмжиж болшгүй нөлөөтэй байдаг. Сүүлийн жилүүдэд Хятад улс эдийн засгийн давуу хүчин чадлаа улс төр, гадаад харилцааны арга хэрэгсэл болгон ашиглах нь түгээмэл байна. Ялангуяа эдийн засгийн хувьд хараат байдалд орсон түнш улсдаа эдийн засгийн арга хэмжээ авах замаар өөрсдийн улс төрийн байр суурийг нь хүндэтгэн дагахыг тулгадаг. Иймд хоёр талын харилцаанд худалдааны хэмжээ нь улс төрийн шахалт үзүүлэх, нөлөөлөх маш хүчтэй хэрэглэгдэхүүн болж байна. Худалдааны тэнцвэргүй байдал нь түнш улсаас улс төрийн хамааралтай байх боломжийг улам өсгөж байдаг ажээ.

Тухайлбал, Далай ламыг хүлээн авснаас улбаалан тухайн улсын Хятадтай хийх худалдаанд хэрхэн нөлөөлж байгааг Германы судлаач Андреас Фукс, Нильс Хендрик Кланн (Andreas Fuchs and Nils-Hendrik Klann 2010 он) нар “Далай ламын айлчлал олон улсын худалдаанд нөлөөлж буйг” (Paying a Visit: The Dalai Lama Effect on International Trade) статистикт суурилан гаргажээ.

1 З.Болор, БНХАУ-ын ЗХА-ийн бүс нутагт явуулах бодлого, ССХ ЭША

2 Бээжингийн Сяншань батлан хамгаалах форум (北京香山论坛), Үндсэн хуралдаан, 2019 оны 10 дугаар сар, БНХАУ, Бээжин хот

Хүснэгт 1. Улс орнуудын төрийн тэргүүн Далай ламтай уулзсаны дараа БНХАУ-тай хийх гадаад худалдаанд нөлөөлөх нь (дэлхийн хэмжээнд)

	Бараа бүтээгдэхүүний төрөл	Худалдаанд эзлэх хувь хэмжээ	Далай ламын айлчлалын нөлөө
1.	Хүнс, амьд амьтан	1.7 %	-0.197
2.	Ундаа, тамхи	0.2%	0.181
3.	Түүхий эд, уул уурхайн бүтээгдэхүүн	12.1%	-0.140
4.	Эрчим хүчний бүтээгдэхүүн, шатах тослох материал	7.8%	-0.432
5.	Амьган, ургамлын гаралтай өөх тос	1.0%	-0.206
6.	Химийн бүтээгдэхүүн	12.4%	-0.096
7.	Материалаар ангилсан бүтээгдэхүүн	13.3%	-0.031
8.	Машин механизм, тээврийн хэрэгсэл	41.0%	-0.605
9.	Үйлдвэрлэсэн бэлэн бараа бүтээгдэхүүн	7.3%	-0.232
10.	Бусад ангилагдаагүй бараа бүтээгдэхүүн	2.2%	-0.294

Эх сурвалж, Paying a visit: The Dalai lama effect on international trade, Andreas Fuchs and Nils-Hendrick Klann, December 2010

Дээрх статистикаас үзвэл хүнд машин механизмын худалдаа хамгийн их буюу 41 хувийг, химийн бүтээгдэхүүн, түүхий эд, уул уурхайн бүтээгдэхүүн дараалан дийлэнх хувийг эзэлж байна. Ихэнх тохиолдолд ийм төрлийн худалдааг улс төрийн итгэлцэл баг бэх, харилцаа харьцангуй өндөр түвшинд хүрсэн улсууд хийдэг. Эндээс харахад Хятад худалдааны түншийнхээ стратегийн ач холбогдогдолтой буюу өндөр үнэтэй, экспортын орлогын дийлэнх хувийг эзэлдэг бүтээгдэхүүнд энэхүү “арга хэмжээ”-ээ чиглүүлдэг ажээ.

Дэлхийн улс орнуудын гуравны хоёрын худалдааны том түнш болсон Хятадын хувьд эдийн засаг нь зөөлөн хүчний бодлого¹ болдог төдийгүй сүүлийн жилүүдэд улс төрийн нөлөөгөө бэхжүүлэх арга хэрэгсэл болоод байна.

Цаашид Хятадын язгуур ашиг сонирхол зөвхөн “Нэг Хятад” (一国两制 хят.)-ын бодлого түүнтэй холбогдох Тайвань, Төвөд, Шиньжааны зэрэг нэгдмэл байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал төдийгүй бүс нутгийн маргаантай Өмнөд Хятадын тэнгис, Дяо Юй арлаар ч хязгаарлагдахгүй сансар огторгуй, шинэ технологи, Арктик зэрэг орон зайд тэлэх төлөвтэй байна. Бээжин аюулгүй байдлаа хангахын тулд эдийн засгийн давуу талаа ашиглан улс төрийн шийдвэрт нөлөөлөх албадлагын арга барилаа лавшруулсан аюулгүй байдлын бодлого стратеги хэрэгжүүлэх хандлагатай байна.

¹ Joseph Nye, Indo Asia Pacific Defense Forum, Vol.42 Issue 2, 2017